

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Ядамын Жүрмэд	Дугаар	L067
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Чойбалсан хот
Төрсөн газар	Матад сум	Төрсөн он	1921
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Цорж ламын хийд буюу Алтан-Очиртын хийд, Хошуу хийд, Шар овооны хурал, Мэргэн Бандидын хийд	Сүм хийдийн дугаар	ДОМТ 050, ДОМТ 052, ДОМТ 049, ДОМТ 051
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 29	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Матад сумын Цорж ламын хийд буюу Алтан-Очиртын хийд, Хошуу хийд, Шар овооны хурал,
Мэргэн Бандидын хийд

-Танаас бид Матад сумын хийдүүдийн тухай асууж мэдэхээр ирлээ.

Би Матад сумын хүн. 1936,7 оны өвөл сүм хаагдсан. Би яахав 10 хэдтэй нэг жаахан банди сүмд сууж байсан. Хурлын мөрд сууж байсан. Ном мэдээд байх юм юу байхав.

-Та аль хийдэд сууж байсан юм бэ?

Цоржийн хийдэд. Цоржийн хийд гэхээр та нар мэдэх ч үгүй байж мэднэ. Алтан-Очирт ламын хийд гэвэл тэр. Тийм. За тэгээд яахав. Тэнд бол би байшинтай, хашаатай, нэг жаахан гэртэй өвгө аавтай, бас нэг багштай. Багшид очиж ном заалгадаг ийм байсан. За тэгээд яахав. Ирэн очин. Хөдөө чөлөө аваад өгнө өө хөдөө гэр луугаа ийм байсан. За тэгээд миний сууж байсан жинхэнэ миний нутгийн Алтан-Очирт ламын хийд бол их том

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хийд ээ.Зүүн, баруун хоёр хүрээтэй. Гол талдаа Цогчэн дуган, Цанидын дуган, Эмчийн дуган гээд гурван дугантай. Ар талд нь бас нэг жаахан дуган сүмтэй. Одооны амбаарын дайтай жаахан юм байсан. Тэрэнд Алтан-Очиртын шарилыг залж байсан. Зэрэгцүүлээд тэр зүүн талд нь нэг нүгнээ сахидаг нэг өвгөн лам байсан юм байна лээ. Тэр ламыг бүр хөдөө оршуулсныг Алтан-Очирт лам амьд сэрүүн байхдаа авчруулаад гонхон бариулаад хийсэн юм байна лээ. За тэгээд ер нь хурал гэдэг юм тоймгүй их , олон байсан. Янз бүрийг айлтгал айлтгасан юм жигтэйхэн их. Өглөө Цогчэн хурна.Цогчэнгүй хурал гэж байх биш дээ. Орой Дайнзан хурна. За тэгээд болно оо. Ер нь хүрээ дэгтэй. Одоо Гандан ямар байсан яг тэрэн шиг байсан байгаа юм. Да лам гэж хамгийн тэргүүн лам нь байсан. Тэрний дараа Дэмч гэдэг лам байсан. Тэрний дараа нь их унзад,бага унзад гээд хоёр унзадтай. Хоёр гэсгүйтэй. Их, бага. Их сайхан бүдүүн дөрвөлжин төмөр бэрээтэй. Гэсгүй хүрэн жанчтай. Гэсгүйг босоод ирэхээр ухаан гарна. Айна гэж жигтэйхэн. Ийм байлаа. Тэгээд яахав заалгаж үзэж гийсэн нь ховор. Гэхдээ яахав ээ, хурлын уншлага заалгасан. Одоо ерөөсөө 60, 70 жил хаячихлаар мартчихдаг юм байна.

-Та хэдэн настай анх Алтан-Очиртын хийдэд шавилан суусан бэ?

8 настай байсан.

-Хэд хүртлээ суусан бэ?

16 хүртлээ суусан. 1936,7 оны өвөл, хавар гэрээдээ явсан. Муу байшин саваа цоожилж орхичихоод нутгийн хүн дагаад гэрээдээ. Хонуут өнжүүт айл амьтны үхэр малаас бүсээрээ оосорлож унаад нэгийг нь тавиад дахиж нэгийг барьж унаад одоо энэ газрын тос байгаа газарт очиж байсан юм. Дов гүв гэдэг газар. Ийм юм даа.

-Матад сумын нутагт ямар ямар хийд байсан юм бэ?

За тэгээд манай нутагт , Матад сумын нутагт Алтан-Очиртын хийдийн баруун талд 10 хэдэн км-н юмүү 10-аад км-н зайтай Бандид, мэргэн Бандидын хийд гэж бий. Байсаан. Бандид ламхай гэж нэг хүн байсан.Тэрнээс баруунтш Баруун Артын үгүй ээ, Зүүн Артаас баруун тийш Овоон гудсын хавьцаа юм уу даа тэнд нэг суурь байгаа.Тэнд Хошуу хийд гэж байсан.Ийм л юм. Хойшоо Арын хамбын хийд байсан. Тэр бол хамба юм. Хүзүүвч гэдэг газарт л байсан юм даа. Одоо Жаргалант уулын баруун дор. Ингээд гурван хийд. За энэнээс зүүн тийш Тээгийн сүм гэдэг сүм байсан. Хоёр хурал байсан. Өө тэр чинь тов хийсэн хоёр хөөрхөн дугантай, нэг том , хоёр жижиг. Сайхан хоёр дугантай байсан. Хоёулаа 5 хаан сахиустай байсан. Тэр Тээгийн дуган бол хэрмэн хашаатай. Том сүм нь дээрээ ганжир, жанцан, сэрээ, мэрээтэй. Ер нь их сайхан. Жижиг гонхон гэвэл хойд талд нь нэг жижиг нь гонхон дуган байсан. Энэний дайтай хоёр юм байсан байх. Зай нь (өрөөнийхөө хэмжээгээр жишээлэв) Тэрэнд нь хурал хурдаггүй. Цайдамын сахиус, бурхад нь тэндээ. Юмынх нь томдоо. Намар айлууд говь руу нүүдэг тэр үеэр Цайдамын чинь хойд талдаа том байшинтай.Олон тогоотой. Тогооч, нярав, ажилчин ихтэй. Тэндээ хурал хурна. Юмын хурал 10 хоног, Цайдамын хурал 10 хоног хурна. Хоёр хурлын эцэст нь Чойжоо Дүгжүү залдаг. Ийм байсан. Хамгийн сүүлийн хуралд, хурал хураад хурлын дараа айлтгал ирдэг юм. Дарам гээд хүн хэдэн хар хүнтэй. Би тэрэнд мөн оролцож хийлцэж л байсан даа. Жаахан гэхгүй. Шороо мороо чихээд. Тэрэнд нь мод хатгаад. Гар марыг нь модонд зоогоод, дээгүүр нь юм нөмөргөөд. Ингээд тавьчихдаг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жинхэнэ миний сууж байсан Алтан-Очиртын хийд сор зална. Мялын цам тоглоно. Хар, Цагаан өвгөн, Шаралдай, Боролдой, 2 буга, 2 нохойтой. Хэдэн багтай улсууд цамд тоглоно. Мял богд хоёр боть ном барьсан байдаг. Горимыг нь мэддэг хүмүүс, багийг нь хийж байсан урчуудыг бүгдийг бариад бариад явчихсан.

Өвгөн дуган гэж байсан. Тэр хийдэд. өвгөн дуган гэдэг чинь одоо ухаан 3 давхар. Хоёр давхарт гараад харахад дээрээ цоорхой. Сүмийнх нь орой вааран дээвэртэй. Ганжир манжир бүх юм нь харагдаж байдаг. Тийм байдагсан. Тэгээд нэг тэр 3 давхрын дээд талд нэг дуган байх. Тэр дуганд нь Ямандаг бурхан байх. Алтан-Очирт багшийн сахиус нь юм. Доороосоо шууд явсаар байгаад шатаар гараад явчихна. Тэнд очиж сахиусанд мөргөнө. Ийм л байсан даа. Цагийн хурал гэж зун чинь нэг цуглаж маань үрэл энэ тэр хурна . Зарим улсууд, настай хүмүүсийн маань үрэл нь өсөөд бумба нь дэлбэрээд тэр баруун урд Жасын нэг хоёр давхар цэнхэр байшин байсан. Тэрний наана очиж байсан юм гэнэ лээ. Үнэн ч юм уу худлаа ч юм уу. Тэрийг би нүдээрээ үзээгүй. Тэгж сонсож байсан.

За цагаан сар болоход хуучны хурал хурна. Тэгээд дараа нь Жаваан Чодва гэж олон хөөрхөн жаахан модон хүн хийдэг байсан. Ийм л юм уу даа.(тохой хэртэй) Тавцан дээр. Төмөр утсаар гар хөлийг нь хөдөлдөг яг хүүхэлдэй. Одоо лам нар тэрийг чинь ажиллуулаад хөөрхөн хөөрхөн юм их гарна. Дүр тоглоно. Их гоё. За тэр үед чинь цахилгаан гэрэл гэж байх биш. Их сонин сонин юмнууд байсан юм. Зэс агурунд олс тойруулж хийгээд үзүүрийг нь дээш нь гаргаад дотор нь ус хийгээд өвөл цаг болохлоороо хөлдөнө штээ. Тэгээд гадна талаас нь бүтээгээд тэгээд дуганыхаа үүдээр дуган дотуураа 1-р давхарт өлгөчихнө.Тэгээд лаанууд асаана. Тэгээд учиргүй олон өнгийн гэрэл гарна. Мөсний чинь солонгорсон гэрэл байна биз. Тэр гарна. Хачин гоё юм шиг санагдаж байсан. Жаваан Чодвыг чинь Дүйрэг, Дамбий,Чүлтэмрэнцэн, Вангаабазар, Тавний , Дамдин, Гончиг гээд ийм улсууд хийдэг байсан.

- Алтан-Очирын хийдийн сахиусын тухай?

Бүгд сахиустай. Алтан-Очирын хийдийн гол сахиус нь бол Лхам. Зүүн талын Цанидын дуган Гомбо. Чойр, Манба, Маналын дацангийн хойно нэг том дуган. Одоо бол тийм дуган хийхгүй.

-Тэр Өвгөн дуган уу?

Тийм. Тийм дуганыг бол барахгүй.Сайхан том дуган. Тэгээд тараагаад хүн очуулаагүй. Цэргүүд буулгасан даа. 8-р дивизийн цэргүүд. Зис 5 машинаар модыг нь ачаад явчихсан. Манайх байшингаа буулгаад модыг нь аваад Төлөгний худагт аваачиж том худаг бариад гараад. Тэгээд худаг гарсан.Тэгж байсан юм. Тэрнээс хойш чинь 60, 70 жил боллоо. Одоо ч тэр худаг байгаа.

За тэрнээс гадна Алтан-Очиртын хийдийн баруухан хойно нь Зандан зуу гэдэг жижигхэн улаан байшин байсан. Тэрэн дотор нь ганцхан Зуу бурхан байсан.

-Энэ сүм Алтан-Очиртын хийдийнх үү?

Үгүй ээ. Хошуу хийдийнх. Хошуу хийдийн нэг ламын шавь нь Гүмбэн явсан. За чи бол ном мэдэхгүй. Энэ бурханд шүншиг хийх юм аваад ир гэсэн. Өөрийнхөө тааралдсан л юмыг аваад ирээрэй гэсэн. Ингэж хэлээд явуулсан. Энийг надад Дорж гуай надад ярьсан. Шагдарын Дорж. Тэгээд одоо юу авдаг юм билээ гээд явж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байсан. Тэгсэн нэг хэдэн цаас судар байна гэнэ. Ямрыг нь мэдэхгүй. Ердөө хамж аваад л өвөртөлчихсөн. Тэгээд ирээд багшдаа за би бурхан шүншиглэх юм аваад ирлээ гэсэн. Юу аваад ирэв? гэсэн. Нэг ном аваад ирлээ гэсэн. Үзчихээд өө энэ чинь Зуугийн солдив байна штээ. Одоо болно гэсэн. Өөр юм хэрэг байхгүй гээд өөр тэр цай май ердөө хийгээгүй. Суугаа хүний дайтай шармал бурхан байсан.

Алтан-Очиртын хийдэд бол Зуу бурхан гээд нэг том бурхан байсан.

-Аль дугандаа байсан?

Цогчэн дугандаа байсан. Зүүн талд нь Минтүв гээд сандал дээр суусан бурхан байсан. Бусад дуганд нь жижигхэн жижигхэн сахиуснууд тэгээд дэлгэсэн бурхан байсан.

-Алтан-Очиртын хийдийн дуганууд нь модон дуган байсан уу?

Мод байхгүй. Дан туйпуун дуган байсан.

-Хөх тоосго байсан уу?

Тийм тэгэхдээ шавар чулуугаар бариад гадна дотроос нь тоосгоор хавчаардаад хийчихсэн. Жигтэйхэн сайхан. Хачин гоё дуганууд байсан. За Жарун Хачорын суварга гэж нэг том суварга байлаа. Тэр өвгөн дуганы ард байсан. 6,6 8, 8 ч билүү суварганууд хоёр талдаа. Тэрэнд нь ламын дээд дүрүүд энэ тэр байсан. Сүүлд гаргаад хаячихсан байсан. Тэр манай багш ламхайг жаахан дуган дотроос нь гаргаад хаячихсан байсан. Ийм байсан.

- Алтан-Очиртын хийдэд хэдэн лам хүрж байсан бэ?

Суудаг суудаггүй нийлээд 600 шавь нартай. Ихэнх нь гомбоо чөлөө аваад цагийн, их хурал хурахаар ирдэг байсан. Бусад цагт нь чөлөөтэй гадуур.Хөдөө малаараа. Байнгын суудаг нь айхтар хар дээлтэй хамрын тамхи энүүгээрээ гоожуулсан өвгөн лам нар байнга сууна. Тэгээд ном заалгаж байгаа жаахан баньд нар нийлээд 100-аад арай хүрэхгүй хүн байнга сууж байсан. Хошуу хийдэд бол цөөхөн 40,50-иад лам нар. Бандидын хийдэд арай тэрнээсээ бага. Хамбын хийдийг би үзээгүй. Би очиж чадаагүй. Хол хоорондоо. Тэр Тээгийн сүмийг би мэдэж байна. За тэр Хөх усанд Тавсын хурал гэж нэг хурал байсан. Нэг байшинтай. Нэг дугантай. Аа тийм Шар Овооны хурал гээд нэг хурал байсан. Жижигхэн. Мөн энд тэнд гэр дугантай Дагинжирийн хурал гээд ч байж л байсан. Гэр дуган бариад. Гэрийн мод энэ тэр нь худгийн хашаанд л орсон доо. Урьдын улс чинь буян бодоод худаг л хашиж байсан.

-Алтан-Очиртын хийд хэдэн онд байгуудагдсан юм бэ?

Тэрийг би мэдэхгүй ээ. Худлаа хэлээд яахав. Миний л мэдэх байж л байсан.

-Хийдийг Алтан-Очирт лам санаачилсан уу?

Алтан-Очирт лам 7 тодорсон юм. Дунджаар бодвол 300-аад жилийн түүхтэй байх нь. Сүүлийн дүр 27-тойдоо бариа тавианы үед өнгөрсөн юм. Алтан-Очирт лам Бум хурандааг дааж байсан лам. Их сайн лам байсан. Мэргэн ч хүн байсан. Ардын засаг үүсч байхад Бумцэнд хурандааг , цэргийг дааж байсан лам. Тэгээд ухаандаа Монголын засгийн газраас ямар ямар ч билээ цол шагнуулж байсан. Баатар гэсэн үг юм даа гэж Амар гуай,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Шагдар гуай хоёр тэгж байсан. Шагдар гуай аймгийн дарга байсан хүн. Амар гуай нэлээн дээхнэ нас барсан. Тэгж ярьдаг байсан даа.

- Алтан-Очиртын хийдийг төвдөөр юу гэж нэрлэдэг байсан юм?

Юу билээ? Тэргүүн буянт сүм гэж байсан штээ.

-Содномзовулин мөн үү?

Юу билээ.Гол хаалганы тотгон дээр монголоор биччихсэн адрес байсан.

- Яагаад Алтан-Очирт гэж нэрлэсэн юм бэ?

Тэр Алтан-Очирт лам гэдэг чинь хаана одоо аль Далай лам ч юм , эсвэл Банчэн богд очир өгчээ.Тэрүүгээр нь Алтан-Очирт гэж нэр өгчээ. Тэр очир бол айхтар их гоё хийцтэй биш. Зүгээр нэг төмөр утас шиг зэсийг матаад хийчихсэн нэг жаахан жижигхэн юм байсан.

-Малгайны очир биш үү? (Дорнод аймгийн лам Чой)

Үгүй. Тэр гартаа барьдаг очир. Тэр очир энэ хүн Хадаг Паранлэй гэдэг хүн Алтан-Очиртын жавтий лам нь байсан байгаа юм.Одоо ухаан юу, лам жаахан шаралхаж баривал тэр үед нь угааж арчдаг. Дээр нь ном асуувал хэлж өгдөг хүн юм. Шанзав хүн байна штээ.Тэр хүн хийдийг тараахдээр очрыг өөрөө авсан. Тэгээд тэр очир бол байсан. Одоо энэ хэрээ гэж байгаа биз, Батчулуун. Хэрээ Батчулуунд Цэцэг гэдэг хөгшин дээр байсан байна. Тэрийг Хэрээ мэдэж байгаа юм. Би сурсан юм. Тэгсэн тэрнийг лам Төмөр гэж бий штээ. Инээдэг Жамъянгийн хүү.

-Тийм тийм. (Дорнод аймгийн лам Чой)

Тэр аваад. Одоо тэгээд тэрийгээ авъя гэхээр байхгүй ээ. Алга болсон. Ингэж хэлээд өгдөггүй гэж байгаа юм. Ийм л юм. Миний мэдэх хоёр гэсгүйн дөрвөлжин юу, бэрээ бол хоёр сайхан дөрвөлжин төмөр бэрээ. Бэрээн дотор чинь хийдийн заяг маяг нь байдаг шүү. Зоригтын өндөр гэдэг нь муухай өндөр. Лам ухаантай юм. Тэр худалдаж аваад. Сүм татвараа дийлэхгүй болоод одоо өнөө жижигхэн бурхан янз бүрийнхээ юмыг худалдсан юм. Тэгээд татвараа төлсөн . Тэрний урд жил. Тэгэхэд цагийн хурлын их хурал болохоор өндөр Балдан хоёр бэрээг нь гаргаж өгдөг. Тэгээд хурал тарахаар өнөөхийгөө аваад далд хийдэг.Өөрөө хадгалдаг тийм байсан. Тэр олдохгүй байгаа. Хаана аваачаад булчихсан. Хаана аваачаад нуучихсаныг бүү мэд. Тэр нэг газар булаастай байгаа.

-Хоёр зэс бэрээ юу?

Ийм дөрвөлжин төмөр бэрээ. Үүрэглээд сууж байхад чинь өмнө шалан дээр тас буулгана. Цочоод л тэр өдрөө нойр хүрэхгүй. Ийм байлаа. Одоо бол яахав. Судраа хараад нэг их хурдан бишээ. Тэгээд уншаад л байна.

-Алтан-Очирт ламын тэр очир одоо ямар учиртай юм бэ?

Тэр одоо яахав дээ. Одоогоор бол дурсгал болгож өгсөн юм үү? Яаж өгсөн юм бэ? Одоо. Миний мэдэх хэмжээ ер нь энэнээс илүү байхгүй. Өнөөдөр яахав улаан цав байхгүй дээ гэж бодоод будаанаас жаахан. Тэгээд тоглох нь их дээ. Загнуулна. Гэхдээ би торлогдуулж яваагүй. Гэсгүйн өмнө учиргүй байцаагдаж загнуулж зогсож байсангүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Алтан-Очиртын хийд ямар хийдүүдтэй харилцаа холбоотой байсан бэ? Төвдийн ч юм уу? Төвдийн хийдтэй харилцаа холбоотой байсан уу?

Төвдийн хийдтэй харилцаа холбоотой байсан уу үгүй юу би мэдэхгүй. Харин Гандантэгчинлэн хийдтэй л их холбоотой байсан. Тэндээс удирдлага авдаг. Гандан хийдийн хурлын дэг журам, горим нь адилхан. Хүрээ дэгтэй байсан. Их бага хоёр үнзадтай. Одоо сайхан сайхан лам нар байжээ. Одоо даанч алга. Үхэх гэж байгаа хоёр амьтан л байна. Энд Лувсандэндэв гэж байна. Би байна. Өшөө юм байхгүй дээ. Лувсандэндэв 87-той, би 86-тай.

-Таныг сурж байхад Гандангаас лам нар ирж ном айлдаж байсан уу?

Байгаагүй. За ер нь тэгэхдээ янз бүрийн улсууд явж байсан юм. Тэр бол үнэн. Одоо ухаан янз бүрийн үзэл санаатай улсууд байсан. Явж байсан. Тэр улсууд бол морин тэрэгтэй ч юмуу явж байсан. Хөөгдөж туугдаад. Хөх мухлагт гээд нэг лам явж байсан.

-Хаанаас явж байсан лам юм бол доо? Хөх мухлагт ?

Одоо мэдэхгүй. Аа нэг шөнө л олон томоохон лам банди нарыг нэлээд хэдийг цуглуулчихсан ном тавьж байсан гэж байгаа юм. Ном тавих ч гэж. Ном зааж байсан. Хараал хийдэг. Тэгээд тэр нь мэдэгдээд явуулж байсан гэж ярьж байсан юм. Би чинь айхтар дээр үеийн юмыг мэдэхгүй ч тээ. 1921 онд төрсөн хүн чинь. Тэрнээс хойшихыг л мэднэ шүү дээ. Ийм учиртай юм.

-Алтан-Очиртын хийдэд Алтан-Очирт ламын өөрийнх нь зохиосон ном зохиол байдаг уу?

Байдаггүй ээ. Уулын Их сан гэж байдаг штээ. Уулын Их сан олон газрын нэртэй. Матадхан, Баянтүмэн, Цог-Өндөр гээд зөндөө. Одоо тэрнийг чинь тэр хийдийн лам нар , аль чадалтай лам нар Алтан-Очиртын санаачилгаар зохиосон гэж дуулсан. Матад уулын Их санг. Ямар би яаж байхыг нь үзсэн биш дээ. Алтан-Очирт ламын фото зураг өндөр овоодойтой. Нэг өндөр сандал дээр суусан. Би хадгалаад л яваад байсан. Би чинь намын ажил хийж явсан. Төрийн ажил хийж явсан болохоороо тэрийгээ нуугаад хадгалаад явж байсан. Савны ёроолд хадгалаад байгаад байсан. Тэгээд сүүлд Аким надад тэрийг чинь шинэчлээд сайхан өгсөн.

-Одоо байгаа юу танд?

Ер нь байгаа. Далд байна аа. Бийд бол бий. Хувилаад авна гэвэл болно. Би миний ном судар бүрхан тахил энэ тэрээ юмнууд өөр газар бий. Одоо энэ айлын жаахан байшинд ирээд сар болох гэж байна. Би нэг аваад өгч болно оо.

-Алтан-Очиртын хийдийн гар зураг гэж байдаг уу?

Байхгүй. Өвгөн дуганы л нэг гар зураг явдаг юм сан. Одоо тэр хаа ч явдаг юм. Хэнд ч байдаг юм. Мэдэхгүй. Би энэ Түяа мондийг чинь чи нэг зураад ав аа. Намайг амьд байхад. Зүүн баруун хүрээтэй, сүм дугантай нь юутай хэйтэй нь зураад ав аа гээд. Тэгнэ ээ л гэсэн. Тэгээд одоо байхгүй. Би хэлээд өгнө өө. Тиймэрхүү маягийн сүм байсан гээд. Одоо тэнд ганц суварга ч байхгүй. Хамба ламын хийдийн хажууд нэг байгаа. Алтан-Очиртын хийдийн ар дор нэг сэнжит суварга байсныг надаар заалгаж авсан. Тэнд нэг суварга босгоно гэж Аким ярьж байсан. Бүү мэд.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Та Алтан-Очиртын хийдийн бүдүүвч зургийг зураад өгөөч?

Би муухай зурна.

-Зүгээр ээ. Хамаагүй.

Акимын бичсэн номд Алтан-Очиртын зураг байгаа шүү дээ.

-Ламынх нь зураг уу, хийдийнх нь зураг уу?

Ламын зураг. За урагшаа энэ тал нь харж. Энэ зүүн тал нь. Энэ баруун тал нь. Эхлээд дээрээс нь. Ар дор нь байсан Сэнжит суварга гэж бий. Ийм нэг суваргатай. Энэ доогуур чинь хөсөг тэрэгтэй хүн, морьтой хүн энэ тэр орж гараад явна. Ар дор нь байсан.

-Гадуураа хэрмэн хашаа байсан уу? Хүрээгээ тойрсон?

Байгаагүй. Гороо гэж байсан. Жаран Хачорын суварга гэдэг чинь нэг ийм юм. Энд нэг суварга. Энд нэг суварга. Энчээ нэг суварга. Энд хамгийн сүүлийн дүрийн дээд талын дүрийг суварга шүү. Өвгөн дуган гэдэг маань бол энд байна. Энэ Ямандагийн дуган. Алтан-Очиртын дуган. Энд байсан. Барга. Баргууд байна штээ сайн лам байдаггүй байж. Тэгээд Алтан-Очиртыг их шүтэж ирдэг. Ирэхдээрээ багшид мөргөнө гээд. За та нар цувраад сууж бай хэнхдэгээ яраад гээд. Алтан-Очирт чинь буутай. Винтов.Тэгээд бууддаг. Хамгийн түрүүчийн барга "Хөөх" гэж байсан гэж байгаа. Тэгээд хамгийн сүүлд сууж байсан хүний өврөөс сум нь гардаг байсан гэж. Ингэж ярьж байсан. Алтан-Очиртод донир дагуул гээд янз бүрийн хүмүүс байна штээ. Тэр улсууд тэгж ярьдаг байсан. Жаахан Ёндон гэдэг хүн нэг дорын улсууд. Тэр надад ярихдаа тэгж л ярьж байсан.

- Алтан-Очирт ламыг хаанаас тодруулдаг байсан юм бэ? Тамгатай байсан уу? Халх Богдууд тодруулдаг байсан уу?

Богд тодруулдаг байсан. Сунтаг шүүлгээд. Гурван настай хүүхэд бүртгээд. Тэр чинь их юм ордог гэсэн.Есөн цагаан бэлэг, есөн цагаан тэмээ мөнгөн буйлтай энэ тэр гээд. Тэгж л тодруулдаг. Нүсэр юм болдог байсан. Тэгээд 3 настай хүүхдийг чинь яахав. Өөрийнх авга ах лам, эцгийнх нь ах лам, өндөр Лувсан гэдэг, бид Нааяа лам гэж байдагсан тэр хүн ном зааж байсан.Их аргатай номтой хүн. Сүүлд нь том болохоор нь за би таныг сургах гэж нэлээн оролдлоо. Зодож ч байсан, загнаж ч байсан удаа бий. Одоо би тэгэхгүй. Одоо би шавьд орно. Таны шавь болно таны. Дагва-Ёндон гэж өвгөн лам байсан. Тэрэнд өгнө өө. Ном заалга гэсэн. Тэгээд Дагва-Ёндон гуайг нас барсны дараагаар тэр Хадаг Паранлэй гэдэг хүн байж байгаад тэр очрыг нь авсан. Одоо тэрийг Хэрээ мэднэ. Тэгээд ер нь Төмөрийг (Түмээг) (Дорнод аймгийн лам Чой)

нэг тулгах хэрэгтэй юм. Чи тэр Алтан-Очиртын очир яасан? Чи авсан нь үнэн. Авсан байна. Гаргаад ир. Тэр чинь одоо зүгээр нэг чи бидэн шиг улсууд авч байдаг эд биш ээ. Тэр орон дээр сүм хийд байгуулагддаг юм бол тэр чинь зайлшгүй тэнд байх ёстой юм. Байгуулагддаггүй юм бол эндэх хийдэд байх ёстой гэж тулгана даа. Тэгж л олж авахыг бод. Одоо хаа ч явдаг юм хэн мэдэхэв.

-Алтан-Очирт ламын хувилгаан гээд адис тавиад явж байсан гэсэн. (Дорнод аймгийн лам Чой)

Одоо хаана явна?

-Хотод л яваа даа. (Дорнод аймгийн лам Чой)

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Урд уу?

-Тийм ээ. Хийд энэ тэрээ орхисон ш тээ. (Дорнод аймгийн лам Чой)

Зүгээр л нэг морин дэл дээгүүр ниссэн хар хүн үү?

-Тийм ээ. (Дорнод аймгийн лам Чой)

Ном муу мэдэхгүй. Надаасаа дамаа дор оо. (Түмээ ламыг хэлж байна.) За би ерөөл магтаалуудаа үзэж дуусгаад тэгээд би Гомбыг заалгаж байгаад тэгээд л орхисон хүн юм штээ. Нэрийн ном орчуулга мэдэхгүй.

-Та чойр заалгаж байсан уу?

Үгүй ээ.

- Та Алтан-Очиртын хийдийн жасын сан хөмрөгийн талаар ярьж өгөөч?

Цогчэн жас гээд их жас байсан. Одоо тэр 3 дуганын баруун урд нь зүүнтшээ харсан гал тогооны олон шавар байшинтай, хоёр давхан цэнхэр байшинтай тийм байсан. Тэнд голдуу идэж уух гурил будаа, бараа туруугаа хураадаг байсан байх. Зуны цагт сороо тэнд хийдэг байсан. Балин шинэтгэнэ гээд нэг юм болно.Цагийн хурлын өмнө талд. Одоо тэнд би балин ямар юмаа хийх вэ дээ, балингийн гурил горьдоод явна. Балингийн гурил их гоё штээ. Нэг их гоё шар тостой замбаан гурил. Чимэг энэ тэрийг чинь өөхөөр хийнэ. За да мөн сайхан уран улсууд байсан даа. Хүүхэлдэйн театр хийчихдэг л байсан. Цам дэглээд цамын баг энэ тэрийг хийгээд. Тэр цамын эд хогшил гэдэг ярих юм байхгүй. Жигтэйхэн сайхан юм байсан.

-Тэр жасын мал хөрөнгийг нь ямар хүн хариуцдаг байсан юм бол? Хаана байсан бэ?

Жасад их, бага нярав гэж байна штээ.Цогчэн жас, Цанидын жас, Эмчийн жас, Нүгнээн жас гэж байсан. Сангийн жас гэж тэр ламын дуган шүү дээ. Ямандаг сахиусны том дуган. Бүгд тус тусдаа жастай. Тэр жасын мал эд хогшлыг бол нярав хариуцдаг. За жилийн эцсийн тооллого гэж хийдэг биз дээ? Одоогоор бол. Тэр үед чинь байцаалт хийнэ гэж монгол бичиг мэддэг хар хүнүүд сайн сайн бичдэг хүнүүд тэднийхээс өргөн барьсан морь нэг, за Матад хан уулын хошууны тэр гэдэг хүнээс өргөсөн төлөг хурга гээд бичээд байна. Одооных шиг хонь төд, хурга төд гээд хүснэгтэлж явахгүй штээ. Тэгээд тэрнийгээ бүгдийг нь нийлүүлж байгаад морь төд байна, гүү нь төд байна гээд гаргана. За тэгээд энэнээсээ яаж яаж зарцуулсан. Хуучны хуралд юу, юу зарсан? Цагийн хуралд юу юу зарсан? Тэрийгээ байгаа үлдэгдэл малтай нь тааруулна. Тэр нярав тэгж юм нь дутчихаад гарсым гэж дуулаагүй. Тэгж л байсан.

-Жасын нярваар хэн хэн гэдэг хүн байсан бэ? Мал нь ямар айл дээр байсан?

Мэдэхгүй ээ.

-Ер нь хэчнээн тооны малтай байсан бэ?

За мэдэхгүй ээ. Тэрийг бол сонирхох ч ухаан байхгүй. Жаахан хүүхэд байсан байна.

-Хурал номын талаар?

Ер нь Алтан-Очиртын хийдийн бол байнгын хуралтай. Байнгын хурал чинь өглөөний цогчэн гээд олон юм, тэгээд айлтгалууд байна шүү дээ.

- Алтан-Очиртын хийдэд ямар онцлог хурал хурдаг байсан бэ? Чойрт хурдаг, Манбад хурдаг?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гавжийн дом тавьдаг байсан. Дугуй, дугуй боовнууд өгдөг байсан. Тэнд бидэнд юугаа олдохов дээ. Хошуу мошуухан тэгээд л олж иднэ ш тээ.

-Манбад дом тавьж байсан уу?

Байна. Хоёр дацандаа л хийнэ. Голын тэр Цогчэн дуганд бол хийхгүй.

-Хайлан хурдаг байсан уу?

Түмэн гэлэнгийн, түмэн гэлэнсээд байхдаа яахав, Гандантай адил тийм олон байхгүй л дээ. Ер нь байна. Хайлантай. Цавир гээд нэг юм урдаа дүүжилчихнэ. Нэг жаахан дөрвөлжин даавуу тохойдоо углачихна. Тэгээд хайландаа сууна даа.

-Хайлангаа аль дугандаа хурдаг байсан бэ?

Эмчийн дугандаа хайлан хурдаг байсан.

-Хийдийн мяндагтангуудын нэрсийг санаж байна уу та?

Одоо миний мэдэх л Цогчэн дуганд Да лам гээд Жанцан гээд лам байсан. Тэр хүн татварынхаа мөнгийг хурааж энд (Дорнод аймгийн төвийг хэлж байна) авчирч тушаачихаад гарахад нь за та хэзээ явах вэ? гэхэд, маргааш явна гэсэн. Ороод гараарай гэж хэлсэн. Тэгээд Жанцан гуай маргааш өглөө нь ороод гарах гэсэн. Барьж аваад шоронд хийчихсэн. Тэгээд тэр хүн байхгүй ээ. Энд байсан ах дүү нар нь үхлүүт байхад нь дээгүүр доогуур орж байж чөлөө авч өргөж байж үхүүлсэн. Аа Дэмч гээч нэг хүн байсан. Жамсранжавын Дамбий гэж миний дээд үе. Тэр хүн бол орлогч нь юм даа. 10 жил явсан. Дараа нь их үнзад нь Осорсамбуу гэж байсан. Өндөр Чүлтэмийн Ёндон гэж бага үнзад нь байсан. Өндөр Чүлтэмийн Ёндон баригдаагүй. Осорсамбуу гуай баригдсан.

Гэсгүй нь Тарзад гэдэг лам байсан. 10 жил авсан. Чойрын шунлайвТүмэнгийн Гунгаа гэдэг хүн байсан. Тушаалтнууд сонгуулиар болдог байсан. Гэсгүйг хэнээр сонгох вэ? гээд.

-Хийдийн барилга байгууламж нь ямар материалаар баригдсан байсан бэ?

Олон дархчуудыг тушаалаар авчирч цуглуулж байгаад шавар зуурч түүхий туйпуугаар ханыг нь өрөөд тэгээд модлоод дээвэр нь юугаар ч хийсэн байсан юм бэ дээ. Бодвол гөлмөн төмөр оройтой байсан байх. Дуган сүмийн барилгын мод туйпуугаар 8-р дивизийн хазарм барьсан.

-Хийдийн ном судар, бурхан тахилаас авч үлдсэн юм байна уу?

Хүний гар дээр байдаг юм болов уу? Ээ байхгүй. Би байшинд байсан юмнуудаа авдар савнаас эхлээд юмаа авсан л даа. Тэрийгээ үхэр тэргээр ачиж авчирсан. Тэгээд би сүмийн орон дээгүүр гүйж очих гээд тэгээд загнуулаад юуных нь тэнд чинь очих. Битгий яв чи тийшээ гэж байсан. Тэр бурхан ном, янз бүрийн юмнуудыг бол хүн аваагүй. Айгаад. Авсан байна аа эсэргүү гээд барина.Тийм учраас авч болохгүй гэж айдаг байсан. Хатуу байсан. Тэгээд тэр яасан бүү мэд. Мэдэхгүй. Тэрийг чинь цэрэг хурааж аваачаад, цэргийн дарга нар байна штээ, том зурмал бурханыг нэг даргын орсон чинь Гомбыг аваачаад хулдаасны оронд дэвсчихсэн байсан. Одоо ширдэг дээрээ хулдаас тавьдаг биз дээ. Тэгсэн байсан. Манай авга ах лам тэгж хэлж байсан. Тэгээд та тэрэн дээр нь очиж суув уу? гэсэн дээшээ гараад суу гэж байсан үгүй ээ би тэр доор үүдэнд суугаад цай уучихаад гараад ирсэн гэж хэлж байсан. Сонин юмнууд нээрээ байсан шүү. Одоо тэр Зуу, Минтүв гээд их том том

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бурхануудыг чинь аваачиж толгойг нь доош нь харуулж газар суулгаад доод ёроолыг нь аваад ус хийгээд барилгын поошигны оронд хэрэглэж байна гэсэн юм. Тэгээд сүүлдээ ч тэгээд зэс гуулинд тушаасан юм байгаа биз дээ.

-Алтан-Очиртын хийдэд ном барладаг байсан уу?

Барладаг байсан. Дамчаа гэдэг өвгөн лам байсан. Тэр ном барладаг байсан. Лав л миний сайн мэдэх. Хийморийн дарцагны бар байдаг байсан. Тэрэнд бэх түрхээд даавуун дээр дараад тэгдэг л байсан. Хийж байсан, хийдэг байсан хүн би мэдэхгүй. Хуучин дээр үеийн сийлбэр мод л байдаг байсан.

-Өөр зэс болон модон бараар ном хэвлэдэг хүн байсан уу?

Мэдэхгүй. Тийм томоор олон хуудастай ном хийж байгаагүй байх аа. Миний мэдэх л ер нь байгаагүй дээ.

-Бурхан урлаач, зураач, барималчид байсан уу?

Байлгүй яхав. Уран Содов гээд нэг их айхтар зураач байсан. Алтан-Очиртын хийдэд. Хошуу хийдэд хэд хэдэн айхтар бурхан зурдаг лам нар байсан. Дүйнрэг Дамбий гэдэг чинь их айхтар бурхан зурдаг хүн байсан. Тийм улсууд байсан. Хөөрхөн хөөрхөн бэх хийдэг шаазан савтай. Тант гэдэг биз дээ. Монгол нэр нь. Тэрэндээ будагнуудаа өнгө өнгөөр нь хийгээд ярайтал нь суулгачихсан. Тэгээд тэрүүгээрээ дөрвөлжин жаазанд зурах даавуугаа хийчихсэн зураад суудагсан.

Одоо чинь даавуун дээр зурахаа байчихсан шүү дээ?

-Урлахуйн ухааныхан зурж байгаа. Одоо бид танаас проф Б. Ринчен гуайн гаргасан судалгаанд Матад суманд тэмдэглэгдсэн сүм хийдийн тухай тодруулж хэдэн зүйд асууя? Хадан хошууны хийд гэж ямар хийдээ хэлж байна вэ?

Хадан хошууны хийд ээ?

-Тийм ээ. Чойнхорравжаалин хийд гэсэн байна.

Чойнхорравжаалин гэдэг чинь л Хошуу хийд шүү дээ.

-Энэ хийд нь Алтан-Очиртын хийдээсээ зүүн хойш гэсэн үү?

Тийм, тийм.

-Ойрхон уу? Хэдэн км зайтай вэ?

80-аад км.

-Дараагийнх нь байрладаг гэж байна?

Бандидын хийдийн орноос чинь хойш Бадрах овоо гэж байгаа.

-Алтан-Очиртын хийд маань одоо Галбирт гэдэг газар байна уу?

Мэдэхгүй. Тийм нэр би мэдэхгүй.

-Алтан-Очиртын хийдийн ойролцоох газрын нэр, уул, овоо?

Хийдээс тахидаг уул нь Баяндэлгэр гэдэг уул байна.

-Яг байгаа газрынх нь нэр нь?

Баруун, зүүн Ангархай гэнэ. Ангархайн адагт л юм даа. Хөтөл гэдэг газарт л юм даг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Дараагийнх нь болохоор Содномдаржаалин хийд гэж байх юм. Энэ хийдээ Бандидын хийд гээд Гурван дэрс гэдэг газар байдаг гэжээ?

Тийм. Бандидын хийд, Цэцэг Лхүмбэ гэдэг овоотой. Тийм нэр байхгүй байна уу? Овооны?

-Үгүй. Гурван дэрс гэдэг газар байна. Тийм нэртэй газар байна уу? Энэ яахав ойролцоо газрын нэр байж болно л доо?

Хаа байсан. Гурван дэрс гэдэг чинь Матадаас хойш шүү дээ. Тэрнээс тэнд Гурван дэрс гэж байхгүй. Байхгүй ээ.

-Алтан-Очиртын хийдээсээ хойшоо юм байна? Бандидын хийд, Дашдандарлин, Содномдаржаалин хийд гэдэг чинь нэг л хийд болж таарч байна уу?

Хүн хүн янз янз хэлнэ дээ. Бандидын хийдийн тэнд Гурван дэрс гэдэг газар байхгүй. Бандидын хийд чинь Бадрах овооныхоо урд байдаг юм.

-Ар Жаргалантын хийд гэж байна. Энэ ямар хийд вэ?

Ар Жаргалантын хийд гэдэг чинь Хамба ламын хийд.

-Төвд нэр нь Содномгүндэвлин гэж байна?

Би тэрүүгээр ердөө явж үзээгүй. Орж ч үзээгүй. Хамбын хийд гэж л байсан.

-Алтан-Очиртын хийдээсээ баруун зүгт байсан юм уу?

Үгүй. Баруун хойш.

-Дараагийнх болохоор Шар овооны хурал гэж байна?

Тэр ч яахав. Хадан хөвийн яг урд нь байсан юм. Шар овоо гэдэг овоо бий. Тэнд нэг жаахан хурал байсан.

-Дараагийнх нь болохоор Тээгийн хурал гэж байна?

Тээгийн сүм гэж миний хэлсэн их бага 2 хачин сайхан сүм. Одоо тийм дуган барьж чадахгүй дээ.

-Тээгийн сүм Бор толгой гэдэг газар байгаа юу?

Ойролцоо бий дээ. Зүүн хойно нь Бор толгой гэж бий.

-Тээгийн хийд яг хаана байдаг юм бэ?

Хойд, урд Тээгийн ердөө хойхно. Тээг, Тээгийн хүдгийн хойхно.

-Дараагийнх нь болохоор Тэргүүн баянт сүм гэж байна? Хорголжуут нуур гэсэн байна?

Мэдэхгүй ээ. Тэргүүн буянт гэж Алтан-Очиртын хийдийг л хэлж байлаа.

-Тэгвэл энэ хоёр нэг сүм байх нь уу?

Нэг. Нэг.

-Дараагийнх нь болохоор Ламын сүм гэж байна. Баяндэлгэрийн сүм гэж байна уу?

Хаана? Нэгийг хэчнээн дахин бичсэн юм бэ дээ. Баяндэлгэрийн овоо чинь Ламын овоо. Баяндэлгэрийн дэргэд ухаан Тэргүүн буянт хийд байгаа. Алтан-Очирт ламын хийд.

-Тэгвэл энэ тэмдэглэл дээр Алтан-Очиртын хийдийг 3 тэмдэглэхсэн байна уу?

Тийм байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Тэгвэл Бандидын хийдээ бас Дашдандарлин хийд Бадрах овоо гэж нэг бичээд, Содномдаржаалин хийд Гурван дэрс гэдэг газар байдаг гэж нэг биччихсэн юм уу?

Дашдандарлин. Тэр чинь л Бандидын хийд дээ.

- Бадрах овооны орчимд Гурван дэрс ч юм уу, Цагаан дэрс ч юм уу тийм нэртэй газар байхгүй юу?

Байхгүй. Гурван дэрсэнд дээр үеэсээ юм байгаагүй. Хөлөнбуйрын баргын сүм нэг нүүж тэр Гурван дэрс хавьцаа байсан байх. Зуухтад байсан. Тэр хавьцаа.Зуухт, Гурван дэрс чинь зэрэгцээ газар шүү дээ.

-Содномдаржаалин хийдээ Бандидын хийд гэсэн болохоор Дашдандарлинтайгаа нэг л болж таарах нь үү?

Тийм байх.

- Гурван дэрсэнд хэрвээ хийд байсан бол тэр нь баргын нүүдэллэж явсан хийд л болж таарах нь үү?

Тийм.

-Та хар болоод юу хийж байв?

Би одоо яахав ээ. Сургууль төгсөж мэргэжилтэй болоод , цэрэгт явж цэргийн офицер болоод ирээд нам, захиргаанд дарга, аймгийн захиргаанд, аймгийн төлөвлөгөөний комист мэргэжилтэн, жижиг албан газруудад дарга марга хийж байгаад сүүлд нь өөрийнхөө нутагт Намын үүрийн орлогч дарга хийж байгаад тэтгэвэрт гарсан. Тэтгэвэрт гарснаас хойш ажил хийгээгүй.

-Цэрэгт явахын өмнө ямар сургууль төгсгөсөн бэ?

Худалдааны техникум. Улаанбаатарт. Худалдааны техникум, хүн эмнэлгийн техникум,мал эмнэлгийн техникум, санхүүгийн техникум, холбооны техникум гэсэн 5 техникум байсан. Миний дарга байсан гэдэг бол дэмий юм. Ан их хийж байлаа. Мал ална. Зээр ална.